

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-106-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center"><u>Ханг-глайдер</u>ын үйл ажиллагааны дүрэм (Шинэчлэгдэж байгаа) /7 хуудас/ 2014 оны NZ amend.3</p>	<p align="center">ДЕЛЬТАПЛАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /4 хуудас (үндсэн дүрэм-11 хуудастай байсан)/ 1997 оны NZ original</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг-Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>106.1. Хамрах хүрээ Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1)ИНД-91-ийн шаардлагаас гадна, ханг-глайдерын үйл ажиллагааны нэмэлт шаардлага; (2)ИНД-91-д <u>үл хамаарах</u> ханг-глайдерын үйл ажиллагааны шаардлага.</p>	<p>106.1. Зорилго (а) Энэ дүрмийн зорилго нь: 1/ дельтапланы үйл ажиллагаанд хамаарах ИНД-91-ийн нэмэлт журмыг тогтоох, ба 2/ ИНД-91-ийн зарим заалтаас дельтапланы үйл ажиллагааг чөлөөлөхөд тус тус оршино.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>106.3. Нэр томъёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p>	<p>106.3. Тодорхойлолт</p>	<p>-Нэр томъёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p>106.5. Нисгэгчид тавих шаардлага (а)<u>Ханг-глайдерын</u> нисгэгч нь дараах үүрэгтэй: (1)<u>ханг-глайдерын байгууллагын жинхэнэ гишүүн байх;</u> (2)ханг-глайдерын нисгэгчийн зохих үнэмлэх эзэмшдэг байх; (3)<u>нисгэгчийн үнэмлэхний болон холбогдох зэрэглэлийн эрх, хязгаарлалтыг мөрдөх;</u> (4)тухайн ханг-глайдерын байгууллагын үйл ажиллагааны стандарт болон журмыг мөрдөх. (b)<u>Энэ зүйлийн (а)(2)-т заасныг үл харгалзан, ханг-глайдерын нисгэгчийн зохих үнэмлэх эзэмшдэггүй этгээд нь энэ зүйлийн (а)(1)-д дурдсан ханг-глайдерын байгууллагаас олгосон ханг-глайдерын Сургагч-нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийн шүүд хяналтад ханг-глайдераар үйл ажиллагаа эрхэлж болно.</u></p>	<p>106.5. Нисгэгчид тавигдах шаардлага (а) Дельтапланы нисгэгч нь: 1/ 18 нас хүрсэн; 2/ эрх бүхий байгууллагаас олгосон дельтапланы нисгэгчийн хүчин төгөлдөр гэрчилгээ эзэмшигч байх, ба 3/ делтапланы хувьд тогтоож өгсөн стандарт, журмыг баримталж ажиллана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан. -Amend.2-оор нэмэгдсэн</p>
<p>106.6. Ханг-глайдер болон параглайдерын нисгэгч (шилжилт) <u>Ханг-глайдер, параглайдерын нисгэгч нь дараах гэрчилгээ болон зэрэглэл эзэмших үүрэгтэй:</u> (1) <u>эхлэн суралцагчийн зэрэглэл;</u> (2) <u>сурагчийн зэрэглэл;</u> (3) <u>дунд түвшний зэрэглэл;</u> (4) <u>ахлах зэрэглэл;</u> (5) <u>параглайдерын зэрэглэл-1;</u> (6) <u>параглайдерын зэрэглэл-2;</u></p>		<p>- Part 19-өөс шилжүүлсэн</p>

<p>(7) параглайдерын зэрэглэл-3; (8) параглайдерын Сургагч-нисгэгчийн зэрэглэл; (9) параглайдерын зорчигчийн зэрэглэл; (10) ангилал-1 ханг-глайдерын Сургагч-нисгэгчийн зэрэглэл; (11) ангилал-2 ханг-глайдерын Сургагч-нисгэгчийн зэрэглэл; (12) тусгай үр чадварын зөвшөөрөл.</p>		
<p>106.7. Агаарын хөлгийн НТЧ ИНД-91.101(а)(1)(i)-ийн шаардлага нь ханг-глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.</p>	<p>106.7. Дельтапланы Нислэгт тэнцэх чадвар (а) ИНД-91-ийн холбогдох шаардлага нь дельтапланд хамаарахгүй боловч аюулгүй нисэх нөхцөлийг хангасан байна.</p>	<p>-Amend.1-ээр үл хамаарлын шаардлагыг тодорхой болгосон</p>
<p>106.9. Бүртгэл (а) ИНД-91.107-гийн шаардлага нь ханг-глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй. (б) Дараахаас бусад тохиолдолд нисгэгч ханг-глайдераар үйл ажиллагаа эрхлэхгүй: (1) ханг-глайдерыг нисэх клубийн гэрчилгээнд зөвшөөрсөн журмын дагуу ханг-глайдерын байгууллагад бүртгүүлсэн байх; (2) ханг-глайдерын байгууллагын нисэх клубийн гэрчилгээнд зөвшөөрсөн журмын дагуу дараах байдлаар танигддаг байх: (i) ханг-глайдерын таних тэмдгээр; эсхүл (ii) нисгэгчийн хувийн дугаараар.</p>	<p>106.9. Бүртгэл (а) ИНД-91-ийн холбогдох шаардлага нь дельтапланы үйл ажиллагаанд хамаарахгүй. (б) Дараах шаардлага хангагдаагүй тохиолдолд дельтапланы нисгэгч нь нислэгийг үйлдэхгүй: 1/ дельтаплан нь зөвшөөрөгдсөн журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй бол; 2/ доорх таних тэмдэг олгогдоогүй бол: 2.1 дельтапланы таних тэмдэг; 2.2 нисгэгчийн ялгах дугаар.</p>	<p>-Орчуулга найруулга зассан -Үл хамаарлын шаардлагыг тодорхой болгосон</p>
<p>106.11. Агаарын хөлгийн баримт бичиг ИНД-91.109 болон 91.111-ийн шаардлага нь ханг-глайдераар нислэг үйлдэж байгаа этгээдэд хамаарахгүй.</p>	<p>106.11. Дельтапланы бичиг баримт (а) ИНД-91-ийн холбогдох шаардлага нь дельтапланы нисгэгчид хамаарахгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>106.13. Түлшний шаардлага ИНД-91.305-ын шаардлага нь ханг-глайдераар нислэг үйлдэж байгаа этгээдэд хамаарахгүй.</p>	<p>106.13. Шатахууны шаардлага (а) ИНД-91-ийн холбогдох шаардлага нь дельтапланы нисгэгчид хамаарахгүй.</p>	<p>-Үл хамаарлын шаардлагыг тодорхой болгосон</p>
<p>106.15. Агаарын хөлгийн төхөөрөмж (а) ИНД-91-ийн F Бүлгийн шаардлага нь ханг-глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй. (б) Ханг-глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь тухайн ханг-глайдерыг 30 м-ийн (100 ft) нарийвчлалтай, газраас дээш өндөр заах өндөр хэмжигчээр тоногдсон байна.</p>	<p>106.15. Дельтапланы тоноглол (а) ИНД-91-ийн E бүлэгт заасан шаардлага нь дельтапланы нисгэгчид хамаарахгүй. (б) Дельтаплан нь, газрын гадаргуугаас дээшхи өндрийг даралтаар, 30 м (100 фут) –ээс ихгүй зөрүүтэй, заах өндрийн хэрэглэлээр тоноглогдсон байна.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>106.17 Агаарын хөлгийн техник үйлчилгээ (а) ИНД-91-ийн G Бүлгийн шаардлага нь ханг-глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.</p>	<p>106.17. Дельтапланы засвар үйлчилгээ (а) ИНД-91-ийн Ж бүлэгт заасан шаардлага нь дельтапланы нисгэгчид хамаарахгүй.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

<p>(b)Ханг-глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь ханг-глайдерыг тухайн байгууллагын гэрчилгээнд зөвшөөрсөн журмын дагуу ханг-глайдерын байгууллагын олгосон хүчинтэй тохирлын баталгаатай (warrant of fitness) болохыг бататгана.</p>	<p>(б) Дельтапланы "нислэг үйлдэхэд бэлэн" гэсэн баталгааг ИНЕГ-аас гэрчилгээжсэн байгууллагаас гаргасан гэдгийг дельтапланы нисгэгч бататгана.</p>	
<p>106.19. Аюулгүй байдлын төхөөрөмж Ханг-глайдерын нисгэгч болон зорчигч нь дараах хэрэгсэлтэй байна: (1)ханг-глайдерын байгууллагын стандартад нийцсэн хамгаалалтын хатуу дуулга; (2)ханг-глайдерын байгууллагын стандартад нийцсэн маягийн бэхэлгээ.</p>	<p>106.19. Аюулгүйн тоног төхөөрөмж (а) Дельтапланы нисгэгч нь: 1/ ИНЕГ-аас гэрчилгээжсэн байгууллагын стандартад тохирсон хатуу хамгаалалт бүхий дуулга малгайтай байх, ба 2/ ИНЕГ-аас гэрчилгээжсэн байгууллагын стандартад тохирсон хамгаалалтын бэхэлгээ бүстэй байна.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>В Бүлэг Нислэгийн дүрэм</p>	<p>Б БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ЖУРАМ</p>	
<p>106.51. Хөдөлгөөний давуу эрхийн дүрэм (а)ИНД-91.229(b)-д заасныг үл харгалзан, өндөрлөгөөс халин нисэж (soaring ridge) байгаа ханг-глайдерын нисгэгчийг, тухайн ханг-глайдерын баруун гар талд өндөрлөг байгаа бол, түүний эгц урдаас өөр ханг-глайдер ойртох үед баруун тийш эргэхийг шаардахгүй. (б)ИНД-91.229(d)-д заасныг үл харгалзан, өндөрлөгөөс халин нисэж байгаа ханг-глайдерыг гүйцэж түрүүлэх ханг-глайдерын нисгэгч нь гүйцэгдэж байгаа ханг-глайдерыг өндөрлөгтэй талаар нь гүйцэж түрүүлнэ.</p>	<p>106.51. Нислэгийн хөдөлгөөнд оролцох журам (а) ИНД-91-д заасныг үл харгалзан, уулын эрэгцэг дээгүүр хөөрч байгаа дельтапланы баруун гар талд уулын эрэгцэг байгаа тохиолдолд эгц урдаас ойртох өөр дельтапланд зам тавьж баруун гар тал руу эргэхийг энэ дүрмээр шаардахгүй. (б) ИНД-91-д заасныг үл харгалзан, дельтаплан нь уулын эрэгцэг дээгүүр хөөрч байхдаа өөр дельтапланыг гүйцэж түрүүлэх тохиолдолд уулын эрэгцэг талаар тойрч түрүүлнэ.</p>	<p>-Орчуулга найруулга зассан -Бусад дүрэм рүү хийсэн ишлэлийг тодорхой болгосон</p>
<p>106.53. Үүлнээс зай барих ИНД-91.301(a)(2)-т заасныг үл харгалзан, аливаа этгээд нь дараах нөхцөлд, ханг-глайдераар далайн дундаж түвшнээс дээш (AMSL) 3300 м (11 000 ft) максимум түвшин хүртэл, үүлнээс доош 150 м-ээс (500 ft) хол зайтай ниснэ: (1)G-ангиллын агаарын зайд; эсхүл (2)E-ангиллын агаарын зайд (транспондер-шаардсан агаарын зайнаас бусад).</p>	<p>106.53. Үүлэн доогуурх нислэг (а) ИНД-91-д заасныг үл харгалзан, G ангиллын агаарын зайд нислэг үйлдэж байгаа дельтаплан нь үүлнээс 150 м (500 фут)-ийн доогуур, далайн түвшнээс дээш 3600 м (11000 фут) хүртэлх өндөрт нислэг үйлдэнэ.</p>	<p>-“E” ангиллын агаарын зай нэмэгдсэн -Орчуулга найруулга зассан</p>
<p>106.55. Минимум түвшин өндөр ИНД-91.311(a)(3)-т заасныг үл харгалзан, хэрэв тухайн нислэг нь газарт байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахааргүй бол, аливаа этгээд ханг-глайдераар 150 м-ээс (500 ft) доош өндөрт, өндөрлөгөөс халин нисэж (ridge soaring) болно.</p>	<p>106.55. Хамгийн доод өндөр (а) ИНД-91-д заасныг үл харгалзан, дельтаплан нь газар дээрх хүн ба өмч хөрөнгөд хохирол учруулахгүйгээр 150 м (500 фут)-ээс бага өндөрт нислэг үйлдэж болно.</p>	<p>-“Minimum”-ыг “хамгийн доод өндөр” гэснийг “минимум” болгож өөрчилсөн -Ишлэл хийсээн заалтыг тодорхой болгосон</p>
<p>106.57. Нислэг үйлдэх нөхцөл Аливаа этгээд нь ханг-глайдераар шөнөөр нислэг үйлдэхгүй.</p>	<p>106.57 . Нислэгийн нөхцөл (а) Дельтапланаар шөнийн цагт нислэг үйлдэхийг хориглоно.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>106.59. Хөөргөх талбай Ханг-глайдерын нисгэгч зөвхөн ханг-глайдерын</p>	<p>106.59. Хөөрөлт үйлдэх газар (а) Дельтапланы нисгэгч нь эрх бүхий байгууллагаас хөөрөлт</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

байгууллагаас зөвшөөрсөн хөөргөх талбайгаас хөөрөлт үйлдэнэ.	үйлдэхийг зөвшөөрсөн газраас хөөрөлт үйлдэнэ.	
106.61. <u>Аяллын түвшин</u> <u>ИНД-91.313(a)(1) болон ИНД-91.239(a)-ийн шаардлага</u> нь ханг-глайдераар нислэг үйлдэж байгаа этгээдэд хамаарахгүй.	106.61. Нислэгийн өндөр (a) <u>ИНД-91-ийн холбогдох шаардлагууд</u> нь дельтапланы нислэгт хамаарахгүй.	-Үл хамаарлын шаардлагыг тодорхой болгосон
106.63. <u>Аэробатик нислэг</u> <u>ИНД-91.701(b) болон (c)-гийн шаардлага</u> нь ханг-глайдераар нислэг үйлдэж байгаа этгээдэд хамаарахгүй.	106.63. Уран жолоодлого (a) <u>ИНД-91-ийн холбогдох шаардлагууд</u> нь дельтапланы нислэгт хамаарахгүй.	-Үл хамаарлын шаардлагыг тодорхой болгосон
106.65. <u>Дуудлага</u> <u>Ханг-глайдерын</u> нисгэгч нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний (НХҮ) нэгжтэй хоёр талын радио холбооны төхөөрөмжөөр холбоо барихдаа <u>өөрийн хувийн дугаарыг</u> хэрэглэнэ.	106.65. Дуудлагын дохио (a) <u>Дельтапланы</u> нисгэгч нь хоёр талын радио холбоогоор НХҮА-тай харьцахдаа нисгэгчийн <u>ялгах дугаараа</u> хэлнэ	-Орчуулга найруулга зассан
106.67. <u>Ханг-глайдерыг нислэгт чирэх</u> <u>Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчээс бусад этгээдийг ханг-глайдерыг нислэгт чирэхийг зөвшөөрөхгүй.</u>		-Amend.3-аар нэмэгдсэн

Дүрмийн боловсруулалтын хэлтэс